



**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**№ 04.3.8 ТӨМӨР ЗАМЫН АЧАА ТЭЭВЭР, ГАЛТ
ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Хяналт шалгалтын нэгжийн нэр:

Хяналт шалгалтын төрөл:

Үйл ажиллагааны чиглэл:

Хяналт шалгалтын удирдамжийн дугаар: _____ огноо: / /

Шалгуулагч этгээдийн нэр:

Хяналт шалгалт хийсэн объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийж эхэлсэн огноо: / /

Хяналт шалгалт дууссан огноо: / /

Шаардлага хангасан асуултын тоо: Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо: Эрсдэл үүсэх магадлалын хувь: Эрсдэлийн ангилал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
Нийтлэг шаардлага						
1.	Төмөр замын тээврийн тухай хууль 18.4.1 дэх заалт	Тусгай зөвшөөрөл, гэрчилгээтэй байх;	0	5		
2.	Төмөр замын тээврийн тухай хууль 18.4.2 дахь заалт	Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэжлийн ажилтантай байх;	0	5		
3.	Төмөр замын тээврийн тухай хууль 18.4.3 дахь заалт	Төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм болон холбогдох бусад дүрэм, стандартыг дагаж мөрдөх;	0	5		
4.	Төмөр замын тээврийн тухай хууль 18.4.5 дахь заалт	Эзэмшиж буй төмөр замын объектын тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, тэдгээрийн бүртгэлийг хөтөлж, тогтоосон журам, технологийн дагуу үзлэг, үйлчилгээ	0	5		

		хийх;				
5.	Төмөр замын тээврийн тухай хууль 19.2.4 дахь заалт	Суурь бүтцийн үйлчлэлийн хүрээнд дагнасан хэрэглээний зам эзэмшигчидтэй гэрээ байгуулж, галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах арга хэмжээ авах;	0	5		
6.	Төмөр замын тээврийн тухай хууль 25.3 дахь заалт	Зорчигч, тээш тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зорчигчийн галт тэргийг өртөө, зөрлөгт зөвхөн зориулалтын замаар хүлээн авч явуулах бөгөөд зорчигчийн галт тэргийг хүлээн авах, явуулах зориулалтын зам нь стандарт, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмээр тогтоосон хэмжээний гэрэлтүүлэг, тавцан, талбайтай байна;	0	5		
7.	Төмөр замын тээврийн тухай хууль 25.4 дэх заалт	Төмөр замын байгууллага, нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай эзэмшигч нь тэмдэг, дугаар бүхий хатуу тооцоот багаж, хэрэгсэлтэй байх бөгөөд түүний жагсаалт, ашиглах болон хүлээлцэх журмыг төрийн захиргааны төв байгууллага тогтоож, жагсаалтыг Тагнуулын ерөнхий газарт бүртгүүлнэ.	0	5		
8.	Төмөр замын тээврийн тухай хууль 8.1.3, Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам 2.1.7 дахь заалт	Суурь бүтэц эзэмшигч, тасгийн дарга, салбар хариуцсан удирдлагууд харьяалагдах салбар, нэгжийн байгууламж, төхөөрөмжийн бүрэн бүтэн найдвартай ажиллагаа, ажлын технологийн мөрдөлт, галт тэрэгний хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хэрхэн хангаж байгаад суурь бүтэц эзэмшигчийн тогтоосон хуваарийн дагуу үзлэг шалгалт хийсэн байх. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг хийсэн байх.	0	5		
9.	Төмөр замын тээврийн тухай хууль 29.3 дахь заалт, Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам 3.1.13 дэх заалт	Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилд зохих сургалтад хамрагдаж, тухайн ажлыг гүйцэтгэх эрх авсан, эрүүл мэндийн хувьд тэнцсэн, 18 насанд хүрсэн иргэнийг томилон ажиллуулсан байх.	0	5		
10.	Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл 2.1.6	Албан үүргээ гүйцэтгэхдээ төмөр замын тээврийн хяналтын албаны ажилтан тусгай дүрэмт хувцас, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөн зохион байгуулагч, тээвэрлэлтийн үйлчилгээний ажилтан ялгах тэмдэг бүхий дүрэмт хувцас, бусад ажилтан хөдөлмөрийн нөхцөл, ажил үүргийн онцлогт тохируулсан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай хувцас хэрэглэх.	0	5		
11.	Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл 5	Ажил амралтын дэглэмийн хэрэгжилт нь шаардлага хангасан байх.	0	5		

12.	Төмөр замын техник ашиглалтын журам 2.8, MNS 5833:2010 Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүн овор хэмжээний ерөнхий шаардлага.	Төмөр замын гол болон салбар замын байгууламж, төхөөрөмж нь үндэсний стандартаар тогтоосны дагуу төмөр замд барилга, байгууламжийн ойртох хязгаар, хөдлөх бүрэлдэхүүний "А", "Б", "С" оврын шаардлага хангасан байна. Депо, засварын газар, ачих буулгах талбай болон байгууллага, аж ахуй нэгж, компанийн үйлдвэрийн байгууламж, төхөөрөмж, үйлдвэрийн дэвсгэр нутгийн хоорондох байгууламж, төхөөрөмж нь энэхүү стандартаар тогтоосон төмөр замд барилга, байгууламжийн ойртох хязгаар, хөдлөх бүрэлдэхүүний "Д", "СП" оврын шаардлагыг хангасан байна. Шинээр барих, шинэчлэн сайжруулах байгууламж, төхөөрөмж нь дээр дурдсан стандартын "А", "Б", "Д", "С", "СП" оворот тохирсон байх шаардлагатай. Барилгын засварын болон бусад ажлыг гүйцэтгэхэд байгууламж, төхөөрөмжийн овор хэмжээг зөрчихгүй байх.	0	5		
13.	Төмөр замын техник ашиглалтын журам 5.14, 5.15, 5.16, 5.17, 5.18 дахь заалт	Өртөө, зөрлөгийн зорчигчийн тавцан, парк, дов, сумны бэлчир, гүүр, хамгаалалттай гарам тогтоосон хэмжээний гэрэлтүүлэгтэй байх.	0	5		
14.	Төмөр замын техник ашиглалтын журам 3.3.14, 3.3.15 дахь заалт	Ялгах, хэсгийн, ачааны томоохон өртөөн дээрх ялгах дов, довын бэлийн болон татах замуудын тууш огтлолыг 3 жилд нэгээс доошгүй удаа, бусад замд 10 жилд нэгээс доошгүй удаа тусгай багаж ашиглан шалгана.Зам эзэмшигч аж ахуйн нэгж өөрийн эзэмшилд байгаа замын аж ахуйн бүх төхөөрөмж, байгууламжийн масштаб, бүдүүвч зураг, замуудын дагуу ба хөндлөн огтлолын зураг, баримт бичигтэй байх.	0	5		
15.	Төмөр замын техник ашиглалтын журам 14, 14.1.4, 14.1.5,14.1.7 дахь заалт	Техник захирамжийн актад өртөөний масштабчилсан бүдүүвч, замын дагуу огтлолын зураг, галт тэрэг хүлээн авах, явуулах, сэлгээний ажил хийх заавар, дохиолол төвлөрүүлэлт хориглолын болон холбооны байгууламжийг ашиглах заавар, ялгах дов дээр сэлгээний ажлын заавар, салбар замд сэлгээний ажил хийх заавар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, /аюулгүйн замнал салбар замын хүснэгт зэргийг хавсаргана. Нэмэлт өөрчлөлт оруулсан тухай бүрд актыг шинэчлэх буюу засварлаж байх. Батлагдсан техник захирамжийн актын хуулбарыг ажлын байранд байлгах.	0	5		
16.	Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам 13 дугаар бүлэг	12.5. Галт тэрэгний диспетчерийн үүрэг: 13.61. Галт тэрэгний найруулагчийн үүрэг: 13.63. Галт тэрэгний найруулагч сэлгээний ажил эхлэхийн өмнө гүйцэтгэх үүрэг: 13.65. Сэлгээ хийх үеийн галт тэрэгний найруулагч ба түүний туслахын үүрэг: 13.75. Сэлгээ хийх үед зүтгүүрийн бригадын үүрэг: 13.84. Сэлгээ хийх үеийн сумчны үүрэг: 1.25. Өртөөний жижүүр ажилд гарахын өмнөх үүрэг	0	5		
17.	Галт тэрэгний	Хөдлөх бүрэлдэхүүнийг тоормосны	0	5		

	хөдөлгөөний удирдлагын журмын 12-р хавсралт	ивүүрээр бэхлэх норм хангасан байх.				
18.	Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам 14 дүгээр бүлэг	Анхаарамж олгоход тавигдах шаардлага хангасан байх.	0	5		
19.	Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам 13.113 дахь заалт	Найруулагчийн бригад сумыг шилжүүлж сэлгээний ажил хийдэг хэсэг зам руу сэлгээний бүрэлдэхүүн оруулахын өмнө найруулагчийн бригад сэлгээний бүрэлдэхүүнийг зогсоож зам, сумын байдлыг шалгах ба хөдөлгөөний аюулгүй байдалд саад учрах хүчин зүйл байгаа эсэхийг магадлана.	0	5		
20.	Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам 13.25 дахь заалт	Сэлгээний үеийн хурд	0	5		
21.	Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам 13.24 дэх заалт	Тэсрэх дэлбэрэх аюултай ачаатай вагон, шахсан шингэрүүлсэн хийтэй цистерн байгаа зам руу сэлгээний зүтгүүр оруулах шаардлагатай үед өртөөний жижүүр, сэлгээний зохицуулагч, довын жижүүр, найруулагч нар сэлгээний машинчид тус тус анхааруулан, тухайн вагонд сэлгээ хийх үед анхааруулах хуудас /бичгэн наряд/-аар гүйцэтгэнэ	0	5		
22.	хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 28.1.6	Ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, заавар, журам баталж, мөрдүүлэх.	0	5		
23.	Хатуу тооцоот багаж, хэрэгслийг ашиглах болон хүлээлцэх журам	Хатуу тооцоот багаж, хэрэгслийг ашиглах болон хүлээлцэх	0	5		
24.	Төмөр замын дохиолол, холбооны журам 7.11 дахь заалт	Сэлгээний ажлын үед хэрэглэх дохио, төмөр замын технологийн холбоо нь шаардлага хангасан	0	5		
25.	Төмөр замын дохиолол, холбооны журам 7.3	Сэлгээний гар ба дуут дохиог ашиглаж сэлгээний ажлыг гүйцэтгэж байгаа байдал	0	5		
26.	“Төмөр замын техник ашиглалтын журам”-ын 2-р бүлгийн 2.14 дэхь заалт	Замын дэргэд буулгах буюу ачихаар бэлтгэсэн ачааг төмөр замд барилга, байгууламжийн ойртох болон хөдлөх бүрэлдэхүүний оврын стандартад заасан зайд хурааж бэхэлнэ. Зам засварын ажилд зориулан буулгах чигжээнээс бусад ачааг 1200 мм хіртэл өндөртэй бол захын зам төмрийн толгойн гадна ирмэгээс 2.0 метр, түүнээс өндөр бол 2.5 метрээс ойргүй зайд байрлуулсан	0	5		
27.	Төмөр замын тээврийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт	Кран, машин, механизм техникийн үзлэг үйлчилгээг хийж гүйцэтгэх батлагдсан хуваарь /график/ байдаг, үзлэг үйлчилгээг хуваарийн дагуу тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэдэг. Кран, машин, механизм техникийн паспортыг тухай бүр нь бүрэн хөтөлдөг. Кран, машин, механизм тогтоосон хугацаанд шалгуулж баталгаажуулдаг, тоног төхөөрөмж нь хэвийн ажилладаг	0	5		
28.	“Төмөр замын техник ашиглалтын журам”-ын 2.6 дахь заалт	Галт тэрэгний ачаа тээврийн үзлэг үйлчилгээ хийх, ачаа вагонд засвар, үйлчилгээ хийх батлагдсан технологи горим, технологи карт байх, технологийн картад цаг тухайд нь өөрчлөлт оруулсан	0	5		

		байх.				
29.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл.	Ачилт буулгалт болон сэлгээний ажлыг гүйцэтгэдэг үйлдвэр, байгууллагуудын вагон тэдгээртэй харилцан ажилладаг тоног, төхөөрөмжүүд эрх бүхий байгууллагаас шалгаж баталгаажуулалт хийгдсэн.	0	5		
30.	“Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл журам”-ын 4.2 дахь заалт	Ажилтнууд нь ээлж солилцох үед ачаа вагонд ачаа тээврийн үзлэг, засвар хийхэд шаардлагатай ажлын багаж хэрэгсэл, сэлбэг материалыг батлагдсан жагсаалтын дагуу хүлээлцдэг.	0	5		
31.	Төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, шалгалт авах журам”-ын 4.3 дахь заалт;	Батлагдсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, удирдамжийн дагуу ажилтнуудад техникийн сургалт явуулдаг байх.	0	5		
Өмнөх шалгалтын түүх						
32.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь заалт	Улсын байцаагчийн хугацаатай үүрэг даалгаварыг биелүүлсэн, тогтоосон хугацаанд хариу ирүүлсэн.	0	10		
НИЙТ ОНОО			0	165		

Хяналт шалгалтаар авах арга хэмжээний биелэлт	Биелэлт
Гүйцэтгэлийн шалгалтаар авах арга хэмжээ	Биелэлт

БАТАЛГААЖУУЛАЛТ		
<i>Хяналт шалгалт хийсэн албан тушаалтан</i>	<i>Хяналт шалгалт хийсэн албан тушаалтан</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
/Албан тушаал/	/Албан тушаал/	/Албан тушаал/
/ овог, нэр/	/ овог, нэр/	/ овог, нэр/
/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тэмдэг/	/ гарын үсэг, тамга/

Тайлбар:

.....
.....